

“МОНГОЛРОСЦВЕТМЕТ” ТӨҮГ

ҮЙЛЧИЛГЭЭ АВАХ
ТЕНДЕР ШАЛГАРУУЛАЛТЫН
БАРИМТ БИЧИГ

Тендер шалгаруулалтын
нэр:

ХОРГОЛЖИНГИЙН ҮЙЛДВЭР БАРИХ
/ Багц №1/

Тендер шалгаруулалтын
дугаар:

МРЦМ/20240101299

Улаанбатар хот 2024 он

I БҮЛЭГ. ТЕНДЕР ШАЛГАРУУЛАЛТЫН ЗААВАРЧИЛГАА

А. ЕРӨНХИЙ ЗҮЙЛ

1. Тендерийн цар хүрээ

1.1. Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль (цаашид “Хууль” гэх)-ийн дагуу өгөгдлийн хүснэгтэд заасан захиалагч III бүлэгт тодорхойлсон үйлчилгээ (цаашид “үйлчилгээ” гэх) худалдан авахаар тендер шалгаруулалтыг зохион байгуулна. Тендер шалгаруулалтын нэр болон дугаарыг өгөгдлийн хүснэгтэд заана.

1.2. Тендер шалгаруулалт багцтай бол энэ тухай мэдээллийг өгөгдлийн хүснэгтэд заана.

1.3. Хуулийн 32.5-д зааснаар тендер шалгаруулалтыг урьдчилан зохион байгуулж байгаа үед энэ тухай өгөгдлийн хүснэгтэд заана.

2. Санхүүжилтийн эх үүсвэр болон төсөвт өртөг

2.1. Тендер шалгаруулалтын нийт болон багц тус бүрийн санхүүжилтийн эх үүсвэр, батлагдсан төсөвт өртгийг өгөгдлийн хүснэгтэд тусгана.

3.1. Энэ худалдан авах ажиллагаанд хуулийн 2.1-д заасан төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль тогтоомжийг дагаж мөрдөнө.

4.1. Тендер шалгаруулалтыг Сангийн сайдын баталсан “Цахим системээр худалдан авах ажиллагаа зохион байгуулах, түүний тасралтгүй, аюулгүй ажиллагааг хангах журам”-ын дагуу худалдан авах ажиллагааны цахим систем (www.tender.gov.mn) /цаашид “цахим систем” гэх/-ээр зохион байгуулна.

5. Авлига, ашиг сонирхлын зөрчлөөс ангид байх

5.1. Захиалагч, сонирхогч этгээд, оролцогч болон хуулийн 52.1-д заасан ажилтан, албан тушаалтан Авлигын эсрэг хууль, Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хууль, Өрсөлдөөний тухай хууль, Эрүүгийн хууль болон Зөрчлийн тухай хуулиар хориглосон үйлдэл, эс үйлдлийн талаар холбогдох албан тушаалтан, хууль хяналтын байгууллагад хууль тогтоомжийн дагуу мэдэгдэнэ.

5.2. Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 20, 20¹, 21 дүгээр зүйлд заасан хориглолт, хязгаарлалтад хамаарах этгээд тендер шалгаруулалтад оролцох эрхгүй байна.

6.1. Аж ахуй эрхлэгч нь хуулийн 22.10-т зааснаар үйлчилгээний хураамж тэлснөөр тус тендер шалгаруулалтын сонирхогч этгээд болно.

6.2. Сонирхогч этгээдийн тэлсөн үйлчилгээний хураамжийг аливаа үндэслэлээр буцаан олгохгүй.

6.3. Оролцогчтой холбоотойгоор хуулийн 7.1-д заасан нөхцөл үүсээгүй буюу ерөнхий шаардлагыг хангасан байна.

6.4. Оролцогч хуулийн 6 дугаар зүйлд нийцүүлэн тендер ирүүлнэ.

6. Сонирхогч этгээд, оролцогчид тавигдах ерөнхий шаардлага

6.5.Тендер шалгаруулалтад оролцох гадаадын этгээд үүсгэн байгуулагдсан улсын хуулийн дагуу эцсийн өмчлөгчөөр бүртгэгдсэн этгээдийн мэдээллийг ирүүлнэ.

6.6.Монгол Улсын хуулийн этгээдийн эцсийн өмчлөгчийн мэдээллийг Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн тухай хуульд зааснаар бүртгүүлсэн мэдээлэлд үндэслэнэ.

6.7.Монгол Улсын олон улсын гэрээнд үл нийцэх, худалдааны хоригт хамаарах этгээд тендер ирүүлэх эрхгүй.

7. Туслан гүйцэтгэгч, түншлэлд тавигдах шаардлага

7.1.Тендерт ирүүлэх түншлэлийн гэрээ, туслан гүйцэтгүүлэх гэрээ нь хуулийн 6 дугаар зүйлд заасан шаардлага хангасан байна.

7.2.Туслан гүйцэтгүүлэх гэрээ хуулийн 6.4-т заасныг зөрчсөн бол захиалагч тухайн туслан гүйцэтгүүлэх гэрээ, туслан гүйцэтгэгчид холбогдох баримт бичгийг тендер хянан үзэхэд харгалзан үзэхгүй.

7.3.Түншлэлийн болон туслан гүйцэтгэгчийн хувиар оролцохыг зөвшөөрсөн болохыг түншлэлийн гишүүн болон туслан гүйцэтгэгч цахим системээр баталгаажуулсан байна.

7.4.ТШЗ-ны 7.3-т заасан нь гадаадын этгээд түншлэлийн гишүүн, эсхүл туслан гүйцэтгэгчээр ороход хамаarahгүй.

7.5.Түншлэлийн гишүүн, туслан гүйцэтгэгч тендер шалгаруулалтад оролцох эрхээ хязгаарлуулсан этгээдийн жагсаалтад бүртгэгдсэн хугацаа дуусгавар болоогүй бол ерөнхий шаардлагад нийцэхгүй гэж үзнэ.

Б.АГУУЛГА

8. Тендер шалгаруулалтын баримт бичиг

8.1.Тендер шалгаруулалтын баримт бичиг нь доор дурдсан бүлэг болон түүнд оруулсан нэмэлт, өөрчлөлтөөс бүрдэнэ:
I Бүлэг. Тендер шалгаруулалтын зааварчилгаа;
II Бүлэг. Өгөгдлийн хүснэгт;

III Бүлэг. Техникийн тодорхойлолт, тавигдах шаардлага;

IV Бүлэг. Тендерийн үнэлгээний шалгуур үзүүлэлт;

V Бүлэг. Тендерийн жишиг маягт;

VI Бүлэг. Гэрээний нөхцөл.

8.2.Сонирхогч этгээд ТШЗ, өгөгдлийн хүснэгтэд заасан шаардлага, шалгуур үзүүлэлт, гэрээний нөхцөл, тендерийн жишиг маягт, техникийн тодорхойлолт болон түүнд оруулсан аливаа өөрчлөлт, иш татсан хууль, журам, зааврыг судалж, тэдгээрт нийцүүлэн тендер бэлтгэнэ.

9.1.Сонирхогч этгээд тендер шалгаруулалтын баримт бичигт заасан асуудлаар тодруулга авах бол энэ тухай хүсэлтийг тендерийн нээлтээс ажлын таваас доошгүй өдрийн өмнө бичгээр захиалагчид гаргаж болно.

9.2.Тодруулга авах хүсэлтийг өгөгдлийн хүснэгтэд заасан хаягаар хүлээн авна.

9.3.Тодруулга авах хүсэлтийд үйлчилгээний хураамж төлсөн баримтыг хавсаргана.

9.4.Захиалагч тодруулга авах хүсэлтийн хариуг албан бичгээр үйлдэж, цахим системд нийтэлснээр хүргүүлсэн гэж тооцно.

9.5.Захиалагч тодруулгын үр дүнд тендер шалгаруулалтын баримт бичигт нэмэлт, өөрчлөлт

9. Тендер шалгаруулалтын баримт бичгийг тодруулах

оруулах шаардлагатай гэж үзвэл ТШЗ-ы 11-д заасныг мөрдөнө.

10. Тендер ирүүлэхийн өмнөх уулзалт

10.1. Хуулийн 19.4-т зааснаар уулзалт зохион байгуулах, эсхүл ажлын талбайтай танилцуулах бол Өгөгдлийн хүснэгтэд заана.

10.2. Уулзалтад сонирхогч этгээд, түүний төлөөлөл оролцно.

10.3. ТШЗ-ны 10.1-д заасан уулзалтад оролцоогүй аж ахуй эрхлэгч тендер шалгаруулалт шалгаруулалтад оролцож болно.

11. Тендер шалгаруулалтын баримт бичигт нэмэлт, өөрчлөлт оруулах

11.1. Тендер хүлээн авах эцсийн хугацаанаас өмнө захиалагч тендер шалгаруулалтын баримт бичигт нэмэлт, өөрчлөлт оруулж болно.

11.2. Тендер шалгаруулалтын баримт бичигт нэмэлт, өөрчлөлт оруулсан бол түүнийг цахим системд нийтэлснээр хүчинтэйд тооцогдоно.

11.3. Хэрэв тендер нээхээс ажлын таван өдрийн дотор тендер шалгаруулалтын баримт бичигт оруулсан нэмэлт, өөрчлөлтийг оруулсан бол тендер хүлээн авах эцсийн хугацааг ажлын таваас доошгүй өдөр байхаар тооцож, шаардлагатай хугацаагаар сунгана.

В. ТЕНДЕР БЭЛТГЭХ

12. Тендер шалгаруулалтын баримт бичгийн болон тендерийн хэл

12.1. Тендер шалгаруулалтын зарлал, баримт бичиг, урилгыг гадаад хэлээр давхар нийтэлсэн эсэхээс үл хамааран тендер шалгаруулалтын баримт бичиг, тендер шалгаруулалттай холбогдох албан бичиг, захидал, бусад баримт бичиг, оролцогчийн ирүүлэх тендер монгол хэлээр байх ба өөр хэлээр үйлдсэн тендер, түүний доторх баримт бичиг, мэдээллийг орчуулсан орчуулгыг тендерт оролцогч бэлтгэн ирүүлнэ.

12.2. Зөвхөн гадаад улс, олон улсын байгууллагын зээл, тусlamжийн хөрөнгөөр санхүүжүүлэх үйлчилгээ авах тендер шалгаруулалтын хувьд Монгол Улсын олон улсын гэрээг үндэслэн хэлийг өгөгдлийн хүснэгтэд өөрөөр зааж болно.

12.3. Хэрэв ТШЗ-ны 12.2-т зааснаар бэлдсэн тохиолдолд тендер шалгаруулалтын баримт бичгийн монгол хэл болон гадаад хэлээр бэлтгэсэн хувилбар хоорондоо зөрвөл монгол хэлээр бэлтгэсэн хувилбарыг баримтална.

12.4. Тендер хянан үзэх, үнэлэхэд захиалагч гадаад хэлээр үйлдсэн баримт бичгийн орчуулгыг үндэслэх ба оролцогч өөрөө, эсхүл бусад этгээд орчуулсан эсэхээс үл хамааран үнэн зөв, зөрүүгүй болохыг захиалагчийн өмнө хариуцна.

13. Тендерийн иж бүрдэл

13.1. Тендер нь хуулийн 21.1-д нийцүүлж бэлтгэсэн үйлчилгээ үзүүлэх техникийн болон үнийн санал байна.

13.2. Оролцогчийн бэлтгэж ирүүлэх тендер дараах баримт бичиг, мэдээллээс бүрдэнэ:

13.2.1. ТШЗ-ны 14-т заасны дагуу бэлтгэсэн маягтууд;

13.2.2. оролцогчийн итгэмжлэлгүйгээр төлөөлөх эрх бүхий этгээдээс өөр этгээд тендерийг баталгаажуулсан бол холбогдох хууль тогтоомжид нийцүүлэн олгосон

итгэмжлэл /гадаадын этгээдийн хувьд итгэмжлэлгүйгээр төлөөлөх эрхтэй этгээдийг нотлох баримт/;

13.2.3. ТШЗ-ны 15-д заасны дагуу бэлтгэсэн хувилбарт санал;

13.2.4. оролцогч ТШЗ-ны 16-д заасан ерөнхий шаардлагыг хангасан болохыг нотлох баримт бичиг;

13.2.5. тендерт оролцогчийн чадавх, туршлага ТШЗ-ны 17, 18, 19-д заасан шаардлага, шалгуур үзүүлэлтийг хангахыг нотлох баримт бичиг;

13.2.6. санал болгож буй үйлчилгээ ТШЗ-ны 20-д заасан шаардлагад нийцсэнийг нотлох баримт бичиг;

13.2.7. ТШЗ-ны 21-д заасан үйлчилгээ үзүүлэх төсөв;

13.2.8. ТШЗ-ны 21.6-д заасан тохиолдолд холбогдох тайлбар;

13.2.9. Түншлэлээр, эсхүл туслан гүйцэтгэгчтэй бол холбогдох гэрээ.

13.3. Оролцогч өөрийн тендерийн бүх баримт бичиг, мэдээллийн хүчинтэй байдлыг нягтлах үүрэгтэй бөгөөд үнэн зөвийг захиалагчийн өмнө хариуцна.

13.4. Оролцогч хуулийн 22.7, 22.10-т заасныг үндэслэн тендерийн баталгаа хүргүүлж, үйлчилгээний хураамж төлснөөр тендер илгээнэ.

14.1. Оролцогч V бүлэгт заасан маягтын мэдээллийг хуулийн 21.1.3-т зааснаар цахим системд үүсгэсэн маягтад бөглөж, илгээнэ.

15.1. Өгөгдлийн хүснэгтэд заасан бол хуулийн 11.10-т заасан шаардлагад нийцэх хувилбарт саналыг тендерийн хамт ирүүлж болно.

16.1. Оролцогчийн ерөнхий шаардлага хангасан эсэхийг дараах баримт бичгээр магадална. Үүнд:

16.1.1. ТШЗ-ны 14.1-д заасны дагуу бөглөж ирүүлсэн V бүлгийн Маягт 1.

16.1.2. Ерөнхий шаардлагыг хангасан эсэхийг магадлахтай холбоотой ирүүлэх бусад баримт бичгийг хуулийн 7 дугаар зүйлд нийцүүлэн өгөгдлийн хүснэгтэд заана.

16.2. Гадаадын этгээд нь үүсгэн байгуулагдсан, эсхүл оршин суугаа улсын төрийн эрх бүхий байгууллагаас гаргасан дараах баримт бичиг, эсхүл түүнтэй адилтгах баримт бичгийг ирүүлнэ:

16.2.1. хуулийн этгээд бол улсын бүртгэлийн гэрчилгээ, түүнийг итгэмжлэлгүйгээр төлөөлөх эрхтэй этгээдийг тодорхойлох баримт бичиг;

16.2.2. гадаадын иргэн, харьяалалгүй хүн бол паспорт, түүнийг орлох баримт бичиг;

16.2.3. тендер шалгаруулалт зарласнаас хойших өдрийн байдлаар тухайн улсын хуулиар татварын хугацаа хэтэрсэн өргүй болохыг нотлох баримт бичиг.

14. Тендерийн жишиг маягтууд

15. Хувилбарт санал

16. Ерөнхий шаардлагыг магадлах баримт бичиг

- 16.3.** Захиалагч оролцогчийн ерөнхий нөхцөлийг магадлах зорилгоор зөвхөн ТШЗ-ны 16.1, 16.2.2-т заасан баримт бичгээс бусад баримт бичгийг ирүүлэхийг оролцогчоос шаардахгүй ба шаардлагатай бусад нөхцөлийг оролцогчийн ирүүлсэн мэдэгдэл, хуулийн 15.2-т заасан мэдээлэлд үндэслэн магадална.
- 16.4.** Түншлэлийн гишүүн тус бүр ТШЗ-ны 16.1, 16.2-т заасан баримт бичиг ирүүлнэ.
- 17.1.** Захиалагч ТШЗ-ны 18, 19-д заасан чадавхын болон туршлагын шаардлага тогтооход хуулийн 15 дугаар зүйлийг баримтална.
- 17.2.** Хуулийн 15.2-т заасан цахим системээр дамжуулан шалгах боломжтой, олон нийтэд нээлттэй мэдээллийг нотлох баримтаар ирүүлэхгүй.
- 17.3.** Түншлэлийн хувьд төлөөлөх эрх бүхий гишүүн, гишүүн хамтдаа ТШЗ-ны 18, 19-д заасан чадавхын болон туршлагын шаардлагыг бүрэн хангасан байна.
- 17.4.** Түншлэлийн төлөөлөх эрх бүхий гишүүн ТШЗ-ны 18, 19-д чадавхын болон туршлагын шаардлагын 40-аас дээш хувийг, түншлэлийн гишүүн тус бүр 25 ба түүнээс дээш хувийг хангасан байна.
- 17.5.** Туслан гүйцэтгэгч нь энэ зүйлд заасан шаардлага, шалгуур үзүүлэлтийн өөрт холбогдох хэсгийг хангаж байгааг нотлох баримт бичгийг тендерт ирүүлнэ.
- 18.1.** Хуулийн 16.5-д зааснаар оролцогч өгөгдлийн хүснэгтэд заасан санхүүгийн чадавхын шаардлага хангасан байна.
- 18.2.** Санхүүгийн чадавхын шаардлагыг хангах нотлох баримт ирүүлэхийг захиалагч шаардах бол хуулийн 16.2, 16.4-т заасан баримт бичгээс сонгож өгөгдлийн хүснэгтэд заана.
- 18.3.** Оролцогчийн дансны мэдээлэл, түүний үлдэгдлийн талаар харилцагч банкны мэдэгдлээс бусад банк, санхүүгийн байгууллагын мэдэгдлийг оролцогчийн санхүүгийн чадавхыг хянан үзэхэд харгалзан үзэхгүй. Захиалагч энд зааснаас бусад асуудлаар харилцагч банкны тодорхойлолт ирүүлэхийг шаардахгүй.
- 18.4.** Монгол Улсын хуулийн этгээдийн банк, санхүүгийн байгууллагад тендер шалгаруулалт зарласнаас хойших өдрийн байдлаар хугацаа хэтэрсэн зээлийн өртэй эсэх талаар лавлагааг Зээлийн мэдээллийн тухай хуулийн 4.1.5-д заасан этгээдээс цахим системээр авч, тендерт ирүүлэх ба уг асуудлаар банк, санхүүгийн байгууллагаас лавлагаа ирүүлэхийг шаардахгүй.
- 19.1.** Хуулийн 17.4-т зааснаар оролцогч өгөгдлийн хүснэгтэд заасан техникийн чадавх болон туршлагын шаардлагыг хангасан байна.
- 19.2.** Техникийн чадавх болон туршлагын шаардлагыг хангах нотлох баримт ирүүлэхийг захиалагч шаардах бол хуулийн 17.2.1, 17.2.3, 17.2.4-т заасан баримт бичгээс сонгож өгөгдлийн хүснэгтэд заана.

	19.3. Үйлчилгээ үзүүлэхэд шаардлагатай зөвшөөрөл, эсхүл гэрчилгээ байгаа бол өгөгдлийн хүснэгтэд заана.
	19.4. ТШЗ-ны 19.3-т заасан тусгай зөвшөөрлийн шаардлагыг түншлэлийн гишүүн тус бүр хангасан байна. Хэд хэдэн зөвшөөрөл, гэрчилгээ шаардсан бол түншлэлийн гишүүд хамтдаа бүрэн хангасан байна.
20. Санал болгож буй үйлчилгээ шаардлагад нийцсэнийг нотлох баримт бичиг	20.1. Санал болгож буй үйлчилгээ нь III бүлэгт заасан техникийн тодорхойлолт, тавигдах шаардлагад нийцсэнийг нотлох баримтыг тендерт ирүүлнэ.
	20.2. III бүлэгт заасан техникийн тодорхойлолтын аль нэг зүйлээс зөрүүтэй, орхигдуулсан бол энэ тухай тайлбарыг ирүүлнэ.
	20.3. Үйлчилгээ үзүүлэхтэй холбоотойгоор тендер шалгаруулалтад оролцох эрхээ хязгаарлуулсан этгээдээс бараа, үйлчилгээ авахаар санал болгосон бол шаардлагад нийцэхгүй гэж үзнэ.
21. Тендерийн үнэ ба үнийн хөнгөлөлт	21.1. Оролцогчийн санал болгож буй үнэ, үнийн хөнгөлөлт нь энэ зүйлд заасан шаардлагад нийцсэн байна.
	21.2. Үнийн задаргаанд тусгайлан тусгасан эсэхээс үл хамааран тендерийн үнэд хуулийн 27.13-т заасан зардлыг багтсанд тооцно.
	21.3. ТШЗ-ны Error! Reference source not found. -т заасан төсвийн нийт нийлбэр нь арифметик алдаагүй боловч V бүлгийн маягт 1-д заасан үнээс зөрүүтэй бол төсвийн нийт нийлбэрийг санал болгосон үнэ гэж үзнэ.
	21.4. ТШЗ Error! Reference source not found. -т заасны дагуу үнийн хөнгөлөлт санал болговол үнийн хөнгөлөлт тооцсоны дараах үнийг “тендерийн үнэ” гэж үзнэ.
	21.5. Хууль болон өгөгдлийн хүснэгтэд өөрөөр заагаагүй бол оролцогчийн санал болгосон үнэ нь гэрээний хэрэгжилтийн явцад тогтмол байх бөгөөд тохируулга хийхгүй. Тохируулга хийх нөхцөлтэй үнэ санал болгосон тендерийг шаардлага хангаагүй гэж үзнэ. Өгөгдлийн хүснэгтэд үнийн тохируулга хийхийг зөвшөөрсөн тендер шалгаруулалтад тогтмол үнэ санал болгосон тендер ирүүлсэн нь тендерээс татгалзах үндэслэл болохгүй ба үнийн тохируулга нь гэрээний хэрэгжилтийн явцад тэгтэй тэнцүү гэж үзнэ.
	21.6. Хуулийн 21.5-д заасан тохиолдолд тендер шалгаруулалтын оролцогчийн тендерийн үнэ төсөвт өртгийн 80 хувиас доош бол уг үнэ нь үйлчилгээний хамрах хүрээ, чанар болон гүйцэтгэлд сөрөг нөлөө үзүүлэхгүй талаар үндэслэл бүхий тайлбарыг тендерт ирүүлнэ.
22. Тендерийн валют	22.1. Монгол Улсын олон улсын гэрээ болон хууль тогтоомжид өөрөөр заагаагүй бол тендерийн үнийг Төлбөр тооцоог үндэсний мөнгөн тэмдэгтээр гүйцэтгэх тухай хуулийн 4.1, 4.2-т заасны дагуу үндэсний мөнгөн тэмдэгт төгрөгөөр илэрхийлэхээр заана.
23. Тендер хүчинтэй байх хугацаа	23.1. Оролцогч хуулийн 21.1.1-д заасны дагуу тендер нээснээс хойш өөрийн тендер хүчинтэй байх хугацааг ажлын 30-аас багагүй өдөр байхаар маягт 1-д заана.

23.1. Захиалагч хуулийн 28.8-д зааснаар тендер хүчинтэй байх хугацаа сунгах хүсэлт гаргасан бол оролцогч өөрийн ТШЗ-ны 23.1-д заасан хугацааг сунгаж болно.

23.2. Оролцогч тендерийн хүчинтэй байх хугацааг сунгасан бол ТШЗ-ны 24-т заасан тендерийн баталгааны хүчинтэй байх хугацаа мөн адил тендерийн баталгааны нөхцөлийн дагуу сунгагдахыг баталгаа гаргагч болон оролцогч хариуцна.

23.3. Хуулийн 32.5-д зааснаар тендер шалгаруулалтыг урьдчилан зохион байгуулж буй тохиолдолд оролцогчийн тендерийн хүчинтэй байх хугацаа нь тухайн ажлын санхүүжилтийн эх үүсвэр батлагдсаны дараа гэрээ байгуулах хүртэл хугацаанд хүчинтэй байхаар заана.

24. Тендерийн баталгаа

24.1. Захиалагч хуулийн 14.1-д заасан тохиолдолд төсөвт өртийн 0.5 хувиар тооцсон “Худалдан авах ажиллагаанд баталгаа гаргах, орлого болгох журам”-д нийцсэн тендерийн баталгаа ирүүлэхийг өгөгдлийн хүснэгтэд заана.

24.2. Хуулийн 14.6-д зааснаар дараах тохиолдолд тендерийн баталгааг хуульд заасан хувь, хэмжээгээр улсын орлого болгоно. Үүнд:

24.2.1. ТШЗ-ны 23-т заасан тендер хүчинтэй байх хугацаа дуусахаас өмнө өөрийн тендерээс бүхэлд нь, эсхүл хэсэгчлэн татгалзсан;

24.2.2. гэрээ байгуулах эрх авсан оролцогч гэрээ байгуулах, эсхүл гүйцэтгэлийн баталгаа ирүүлээгүй;

24.2.3. Захиалагчийн шийдвэртэй холбогдуулан Сангийн яаманд гаргасан гомдлыг бүхэлд нь үндэслэлгүй гэж шийдвэрлэсэн.

24.3. Тендер шалгаруулалтыг багцад хуваасан бол тендерийн баталгааг багц тус бүрд ирүүлнэ.

24.4. Түншлэлийн хувьд түүнийг төлөөлөх эрх бүхий гишүүн тендерийн баталгааг ирүүлнэ.

Г. ТЕНДЕР ИЛГЭЭХ, НЭЭХ

25. Тендер баталгаажуулах, илгээх

25.1. Тендерийг хуулийн 22.1-д зааснаар баталгаажуулан, тендерийн баталгаа шаардсан тохиолдолд тендерийн баталгааг ТШЗ 24-т зааснаар илгээнэ.

25.2. ТШЗ-ны 25.1-д заасны дагуу баталгаажуулсан этгээд оролцогчийг итгэмжлэлгүйгээр төлөөлөх эрх бүхий этгээд бол итгэмжлэл ирүүлэх шаардлагагүй.

25.3. Оролцогчийг итгэмжлэлгүйгээр төлөөлөх эрх бүхий этгээд тендерийг тоон гарын үсгээр баталгаажуулсан бол V бүлэгт заасан маягтыг ТШЗ-ны 25.1-д зааснаар тамга, тэмдгээр баталгаажуулсан гэж үзнэ. Энэ тохиолдолд маягтыг баталгаажуулахтай холбоотой итгэмжлэл үйлдэх, хуулийн этгээдийн тамга, тэмдгээр баталгаажуулахыг шаардахгүй.

25.4. Оролцогч хуулийн 22.5-д заасан хүний эмзэг мэдээлэлд хамаарах мэдээллийг ил болгохгүйгээр илгээх бол хуулийн 22.6.3-т заасан мэдэгдлийг V бүлгийн 07-ын дагуу нууцлахгүйгээр ирүүлнэ.

25.5. Хуулийн 22.6-д заасан баримт бичиг, мэдээллийг заавал ил болгож илгээх ба ТШЗ-ны 25.4-т заасан нь тус баримт бичгүүдэд хамаарахгүй. Захиалагч тухайн тендер

шалгаруулалтад нэмэлтээр ил болгох баримт бичгийг өгөгдлийн хүснэгтэд заах ба уг баримт бичиг хүний эмзэг мэдээлэл хамаарах бол мэдээллийн эзний зөвшөөрлийг авсны үндсэн дээр тендер илгээнэ.

**26. Тендер хүлээн авах
эцсийн хугацаа**

26.1. Тендер хүлээн авах эцсийн хугацааг өгөгдлийн хүснэгтэд заана. Огноо, цагийг цахим системийн серверийн цагаар тооцно.

26.2. Захиалагч тендерийн нээлтийг цахим системээр өгөгдлийн хүснэгтэд заасан огноо, цагт зохион байгуулна. Тендерийн нээлтэд оролцогч, эсхүл түүний төлөөлөгч байлцах эрхтэй.

Д. ЗАХИАЛАГЧ ШИЙДВЭР ГАРГАХ

**27. Тендерийн талаар
тодруулга авах**

27.1. Захиалагч тендерийн талаар тодруулга авах тохиолдолд хуулийн 25 дугаар зүйлд заасан журмыг баримтална.

**28. Тендерийг шаардлагад
нийцсэн эсэхийг хянан үзэх**

28.1. Тендерийг хянан үзэхэд хуулийн 26 дугаар зүйлд заасан журам, ТШЗ-ны 13-т заасан тендерийн иж бүрдэл, холбогдох мэдээллийн сангаас илгээсэн мэдээлэл, оролцогч болон түүний тендерийн талаар авсан тайлбар, тодруулгад үндэслэн хянан үзнэ.

29. Тендерийг үнэлэх

29.1. Захиалагч тендерийг хуулийн 27 дугаар зүйл, Сангийн сайдын “Тендер үнэлэх, давуу эрх олгох аргачлал, заавар”-ын дагуу үнэлж, харьцуулна.

**30. Арифметик алдааг
залруулах**

30.1. Тендерийн үнийн арифметик алдааг “Тендер үнэлэх, давуу эрх олгох аргачлал, заавар”-т зааснаар залруулна.

30.2. ТШЗ-ны 30.1-д заасны дагуу арифметик алдааг залруулсан тухай мэдээллийг оролцогчид хүргүүлнэ.

**31. Үнэлгээнд харгалзах
шалгуур үзүүлэлт**

31.1. Өгөгдлийн хүснэгтэд заасан бол IV бүлэгт заасан үнэлгээнд харгалзах шалгуур үзүүлэлтийг мөнгөөр илэрхийлж, харьцуулах үнийг хийсвэрээр нэмэгдүүлнэ.

**32. Тендерийн харьцуулах
үнийг тодорхойлох**

32.1. Тендерийн харьцуулах үнийг тодорхойлоход дараах дарааллыг баримтална:

32.1.1. ТШЗ-ны 21.1-д зааснаар санал болгосон тендерийн үнийг тогтоох;

32.1.2. ТШЗ-ны 21.4-д заасны дагуу санал болгосон үнийн хөнгөлөлт тооцох;

32.1.3. ТШЗ-ны 30.1-д заасны дагуу тендерийн үнэд хийсэн арифметик алдааг залруулах;

32.1.4. ТШЗ-ны 29.1.1, 29.1.2, 29.1.3-т заасан үнийг шаардлагатай бол ТШЗ-ны 22.1-д заасан валютад хөрвүүлэх;

32.1.6. ТШЗ-ны 31.1-д заасан үнэлгээнд харгалзах шалгуур үзүүлэлтийг мөнгөөр илэрхийлж тооцох.

32.2. ТШЗ-ны 1.2-т заасны дагуу хоёр ба түүнээс дээш багцтай тендер шалгаруулалтад хэд хэдэн багцад хамтад нь хамгийн бага харьцуулах үнэ санал болгосон тендерийг тодорхойлох, түүнд санал болгосон үнийн хөнгөлөлтийг тооцоходо дараах аргачлалыг баримтална:

32.2.1. багц тус бүрийн хамгийн бага харьцуулах үнэтэй тендерийг сонгох;

32.2.2. хоёр ба түүнээс дээш багцад гэрээ байгуулах эрх авсан тохиолдолд үнийн хөнгөлөлт үзүүлэхээр санал болгосон тендерийн үнээс уг үнийн хөнгөлөлтийг тендер илгээх маягтад тодорхойлсон аргачлалын дагуу тооцсоны дараа шаардлагатай бол түүний харьцуулах үнийг дахин тодорхойлно. Ийнхүү тодорхойлохдоо хоёр ба түүнээс дээш багцад хамгийн бага харьцуулах үнэтэй тендер ирүүлсэн этгээд нь ТШЗ-ны 34-д зааснаар дахин магадлахад шаардлага хангаж байхыг шаардана;

32.2.3. дээрх үнэлгээг хийсний дараа тендерийн харьцуулах үнэд үндэслэн захиалагч гэрээ байгуулах эрхийг нэг багцад, хэд хэдэн багцад, эсхүл бүх багцад олгох хувилбаруудыг тооцож, гэрээний үнийн нийлбэр нь хамгийн бага байх хувилбарыг сонгох.

32.3. ТШЗ-ны 15.1-д зөвшөөрсний дагуу хувилбарт санал ирүүлсэн тендер “хамгийн сайн” гэж үнэлэгдсэн бол түүний хувилбарт саналыг хянан үзэж, үнэлнэ.

32.4. ТШЗ-ны 32.3-т зааснаар тендерийн саналын хувилбарыг хянан үзэх, үнэлэхэд үндсэн тендерийг үнэлсэн журмыг баримтална.

33. Тендерийг эрэмбэлэх 33.1. Захиалагч тендеруудийг эрэмбэлэхэд хуулийн 27.5, 27.6-д заасныг баримтална.

34. Оролцогчийн чадавхыг дахин магадлах 34.1. Захиалагч хэд хэдэн багцад хамгийн сайн үнэлэгдсэн тендер ирүүлсэн оролцогчийг тэдгээр багцад заасан гэрээний үүрэг гүйцэтгэх чадавхтай эсэхийг, мөн санал болгосон хүний нөөц, тоног төхөөрөмжийн мэдээлэл өөр бусад төсөл, арга хэмжээний мэдээлэлтэй давхацсан тохиолдолд дахин магадална.

34.2. ТШЗ-ны 34.1-д заасны дагуу дахин магадлахад зөвхөн ТШЗ-ны 18.1-д заасан санхүүгийн чадавх, ТШЗ-ны 19.1-д заасан техникийн чадавх, туршлага, гэрээний үүрэг гүйцэтгэх чадавхын шаардлага, шалгуур үзүүлэлтийг хангах эсэхийг тендер хянан үзэхэд ашигласан баримт бичиг, мэдээлэлд үндэслэнэ.

34.3. Оролцогчийн чадавхыг дахин магадалж, хуулийн 27.10-т зааснаар гэрээ байгуулах эрх олгоно.

Е. МЭДЭГДЭЛ ХҮРГҮҮЛЭХ, ГЭРЭЭ БАЙГУУЛАХ

35.Мэдэгдэл хүргүүлэх 35.1. Захиалагч хуулийн 28 дугаар зүйлд заасан шийдвэрийг хуулийн 24.1-д зааснаар ажлын 15 өдрийн дотор гаргаж, оролцогчдод мэдэгдэнэ.

36.Гүйцэтгэлийн баталгаа 36.1. Хуулийн 42.1-д заасан тохиолдолд гэрээ байгуулах эрх авсан оролцогч тухайн төсвийн жилд санхүүжих дүнгийн гурван хувийн үнийн дүнтэй гүйцэтгэлийн баталгааг захиалагчаас шаардсан хугацааны дотор ирүүлнэ.

36.2. Гүйцэтгэлийн баталгаа, урьдчилгаа төлбөрийн баталгааг “Худалдан авах ажиллагаанд баталгаа

гаргах, орлого болгох журам"-д нийцүүлэн гаргана.

37.Урьдчилгаа төлбөр

37.1. Гэрээг хэрэгжүүлж өхлүүлэхтэй холбогдох зардалд урьдчилгаа төлбөр олгохгүй.

38.Гэрээнд гарын үсэг зурж баталгаажуулах

38.1. Захиалагч VI бүлгийн гэрээний нөхцөлийн гэрээ баталгаажуулах маягтыг түүнд заасан зааврын дагуу шаардлагатай хэсгийг эцэслэн нөхөж, оролцогчид хүргүүлнэ.

38.2. Захиалагч тендер шалгаруулалтын үр дүнд нийлүүлэгчтэй гэрээ байгуулахад тендер шалгаруулалтын баримт бичгийн VI бүлэг дэх гэрээний нөхцөлийг баримтална.

38.3. Шалгарсан оролцогч ТШЗ-ны 38.1-д зааснаар ирүүлсэн гэрээнд гарын үсэг зурж, баталгаажуулан захиалагчаас шаардсан хугацааны дотор хүргүүлнэ.

38.4. Захиалагч хуулийн 30.4-т зааснаар ажлын 10 өдрийн дотор гэрээг баталгаажуулаагүй бол гэрээ байгуулах шийдвэрт заасан нөхцөлөөр гэрээ байгуулсанд тооцогдоно.

39.Тендер шалгаруулалтын гомдол

39.1. Хууль болон Сангийн сайдын баталсан “Тендер шалгаруулалтын гомдол хянан шийдвэрлэх журам”-ын дагуу гомдлыг хянан шийдвэрлэнэ.

II БҮЛЭГ. ӨГӨГДЛИЙН ХҮСНЭГТ

ТШЗ-ны холбогдох заалт	А. ЕРӨНХИЙ ЗҮЙЛ
ТШЗ 1.1	Захиалагч: “ Монголросцветмет ” төрийн өмчийт үйлдвэрийн газар
ТШЗ 1.1	Тендер шалгаруулалтын нэр: Хорголжингийн үйлдвэр барих <i>Багц №1 Төмрийн хүдрийн хорголжлох үйлдвэрийн хагас үйлдвэрлэлийн туршилт, үйлдвэрлэлийн технологийн зураг төсөл боловсруулах</i>
ТШЗ 1.1	Тендер шалгаруулалтын зарлалын дугаар: МРЦМ/20240101299
ТШЗ 1.2	Тендер шалгаруулалт нь дараах нэр, дугаар бүхий багцуудаас бүрдэнэ: <i>Багц №1 Төмрийн хүдрийн хорголжлох үйлдвэрийн хагас үйлдвэрлэлийн туршилт, үйлдвэрлэлийн технологийн зураг төсөл боловсруулах</i>
ТШЗ 1.3	Тендер шалгаруулалтыг урьдчилан зохион байгуулж байгаа эсэх: “ Үгүй ”
ТШЗ 2.1	Санхүүжилтийн эх үүсвэр нь: Захиалагч өөрийн хөрөнгөөр
ТШЗ 2.1	Нийт төсөвт өртөг: Нийт төсөвт өртөг: 17,000,000,000.00 /арван долоон тэрбум/ төгрөг <i>Багц №1-571,290,000.00 /таван зуун далан нэгэн сая хоёр зуун ерэн мянга/</i>
Б.АГУУЛГА	
ТШЗ 9.1	Тендер шалгаруулалтын баримт бичгийн талаар тодруулга авах хаяг: Хүлээн авагчийн нэр: Худалдан авалт, борлуулалтын хэлтэс Хаяг: Улаанбаатар хот, Баянзүрх дүүрэг 22-р хороо, Энхтайваны өргөн чөлөө-98, “Монголросцветмет” ТӨҮГ Утасны дугаар: 11-450060 Цахим шуудангийн хаяг: mailbox@monros.mn Тендерийн баримт бичигтэй холбоотой тодруулга, нэмэлт мэдээлэл авах хүсэлт гаргахдаа “Худалдан авах ажиллагааны цахим системээр тендер шалгаруулалт зохион байгуулах, холбогдох мэдээллийг зарлан мэдээлэх журам”-ын 3.3.4-т заасны дагуу www.tender.gov.mn -д тоон гарын үсгээр баталгаажуулан цахимаар гаргах бөгөөд утсаар тодруулга, мэдээлэл өгөх боломжгүй болно
ТШЗ 10.1	Тендер ирүүлэхийн өмнөх уулзалт зохион байгуулах эсэх: “ үгүй ” <i>Тендерт оролцогч албан бичгээр хүсэлт гаргавал объектын талбайтай танилцах болон тодруулах уулзалтыг зохион байгуулж болно.</i>
В. ТЕНДЕР БЭЛТГЭХ	

ТШЗ 12.1	Тендер шалгаруулалтын хэл: Монгол хэл.
ТШЗ 15.1	Хувилбарт санал ирүүлэхийг: “Зөвшөөрөхгүй”
ТШЗ 16.1.2	<p>Ерөнхий шаардлагыг магадлахад шаардагдах бусад баримт бичиг: “Шаардана”</p> <p><i>Тендерт оролцогч дараах нөхцлүүдийн аль нэг нь үүсээгүй тухай мэдэгдлийг бичгээр гаргана. Үүнд:</i></p> <ol style="list-style-type: none"> 1. Төлбөрийн чадваргүй болсон, татан буулгах шийдвэр гарсан, төлбөрийн чадваргүйдлийн ажиллагаа эхэлсэн, бизнесийн үйл ажиллагааг зогсоосон, эсхүл үүсгэн байгуулагдсан улсын хуулийн дагуу эдгээртэй адилтгах нөхцөл байгаа; 2. Монгол Улсын, эсхүл үүсгэн байгуулагдсан улсын хуулийн дагуу өр төлбөр төлүүлэх шүүхийн шийдвэр гүйцэтгэх ажиллагаа явагдаж байгаа, эсхүл татварын, эсхүл нийгмийн даатгалын шимтгэлийн хугацаа хэтэрсэн өртэй; 3. Өрсөлдөөний тухай хуулийн 4.1.6-д заасан харилцан хамааралтай этгээдийн оролцсон тендер шалгаруулалт, түүний багцад тендер ирүүлсэн; 4. Тухайн тендер шалгаруулалтад оролцохдоо бусад оролцогчтой өрсөлдөөнийг хязгаарлахад чиглэсэн гэрээ, хэлцэл байгуулсан, эсхүл үнэ, бусад нөхцөл, шалгуурыг урьдчилан тохиролцсон; 5. Захиалагчаас хараат этгээд эсэх; 6. Тендерт оролцогч, эсхүл түүнийг төлөөлөх эрх бүхий этгээд, оролцогч компанийн эрх бүхий албан тушаалтны аль нэг нь авлигын, эсхүл мөнгө угаах гэмт хэрэг үйлдсэнийг тогтоосон шүүхийн шийдвэр хуулийн хучин төгөлдөр болсон; 7. Тендер шалгаруулалтын баримт бичгийг болоевсруулахад зөвлөгөө өгсөн, оролцсон, эсхүл тухайн зөвлөгөө өгсөн, оролцсон этгээдтэй харилцан хамааралтай; 8. Тендер шалгаруулалтад оролцох эрхээ хязгаарлуулсан этгээдийн жагсаалтад бүртгэсэн хугацаа дуусаагүй; 9. Тендер шалгаруулалтад оролцох эрхээ хязгаарлуулсан этгээдийн эцсийн өмчлөгчийн үүсгэн байгуулсан, эсхүл эцсийн өмчлөгчөөр бүртгэгдсэн хуулийн этгээд.
ТШЗ 18.1	<p>Санхүүгийн чадавхын шаардлага: “Шаардана”</p> <p>Борлуулалтын орлогын хэмжээ: 2021, 2022, 2023 онуудын аль нэг жилд гүйцэтгэсэн борлуулалтын хэмжээ нь батлагдсан /багцын/ төсөөт өртгийн 80 хувиас багагүй байх.</p> <p>Түргэн хөрвөх хөрөнгийн хэмжээ төсөөт өртгийн 30 хувиас багагүй байх.</p> <p>Монгол Улсын, эсхүл үүсгэн байгуулагдсан улсын хуулийн дагуу өр төлбөр төлүүлэх шүүхийн шийдвэр гүйцэтгэх ажиллагаа явагдаж байгаа, эсхүл</p>

	<p>татварын, эсхүл нийгмийн даатгалын шимтгэлийн хугацаа хэтэрсэн өргүй байх</p> <p>Сүүлийн гурав жил 2021,2022,2023 оны хугацаанд үүсгэн байгуулагдсан улсын хуулийн дагуу гаргасан санхүүгийн тайлан /цахим/;</p> <p>Сүүлийн 3 жил буюу 2021,2022,2023 онуудад ашигтай ажилласан байх</p> <p>Сүүлийн гурав жил 2021,2022,2023 оны хугацаанд оролцогчийн хэрэгжүүлсэн бараа, ажил, үйлчилгээний борлуулалтын орлогын мэдээлэл.</p>
ТШЗ 18.2	<p>Санхүүгийн чадавхыг хянан үзэхэд үндэслэл болгох баримт бичиг:</p> <ul style="list-style-type: none"> - Оролцогчийн санхүүгийн чадавхыг хянан үзэхэд үндэслэл болгох санхүүгийн тайлангийн хугацаа: 2021, 2022, 2023 он - харилцаач банкны мэдээгэл; - Монгол Улсын хуулийн этгээдийн банк, санхүүгийн байгууллагаад тендер шалгаруулалт зарласнаас хойши хөдрийн байдлаар хугацаа хэтэрсэн зээлийн өртэй эсэх талаар Зээлийн мэдээллийн тухай хуулийн 4.1.5-д заасан этгээдийн лавлагаа; - сүүлийн гурав /2021,2022,2023/ жилийн хугацаанд үүсгэн байгуулагдсан улсын хуулийн дагуу гаргасан санхүүгийн тайлан; - сүүлийн гурав хүртэл жилийн хугацаанд оролцогчийн хэрэгжүүлсэн бараа, ажил, үйлчилгээний борлуулалтын орлогын мэдээлэл. - санхүүгийн тайландаа аудит хийлгэх үүрэгтэй оролцогчийн хувьд санхүүгийн тайландаа хийсэн аудитын дүгнэлт.
ТШЗ 19.1	<p>Техникийн чадавх болон туршлагын шаардлага: “Шаардана”</p> <p>Үйлчилгээ үзүүлэх хүний нөөц: “Шаардана”</p> <p>1. Тендерт заагдсан хагас үйлдвэрлэлийн туршилт судалгаа, шинжилгээний ажлыг гүйцэтгэх, дүгнэлт тайлан, зөвлөмж боловсруулах чадвартай боловсон хүчинтэй байх.</p> <p>2. Төслийн судалгаа, туршилт шинжилгээний ажлын дүнгээр технологийн ажлын иж бүрэн зураг төсөл, баримт бичиг боловсруулах багийн боловсон хүчиний мэргэшил, туршлагын шаардлага:</p> <p><i>Төслийн ерөнхий инженер –1 хүн / төслийн ажлын туршлага 5 жилээс баагүй/, Төсөл боловсруулаагч багийн ИТА-4 хүнээс баагүй /төслийн ажлын туршлага 3 жилээс баагүй байх. Үүнд: төмөрлөгийн үйлдвэрлэлийн технологийн зөвлөх инженер болон төмөрлөгийн үйлдвэрлэлийн технологи, цахилгаан, автоматик, дулааны мэргэшсэн болон төслийн ажлын зураг төслийг боловсруулах ИТА мэргэжилтэй боловсон хүчинтэй байх</i></p> <p>Боловсон хүчиний талаар ирүүлэх материалууд</p> <ol style="list-style-type: none"> 1. Дээрх инженер-техникийн ажилтнуудын жагсаалтыг маягт 7, төслийн ажилтнуудын резюмэг Маягт10-д заасны дагуу гаргаж ирүүлнэ. 2. Хүснэгтэд заасан инженер-техникийн болон мэргэжилтэй ажилтнуудын 50-аас доошгүй хувь тендерт оролцогчийн үндсэн ажилтан байна. Тэдгээрийн нийгмийн даатгалын шимтгэл төлөлтийг мэдээллийг тендертээ ирүүлнэ. Үүнийг Төрийн худалдан авах ажиллагааны цахим систем (www.tender.gov.mn)- ээр дамжуулан шалгана.

	<p>3. Тендерт оролцогч тухайн ажлыг гүйцэтгэх инженер-техникийн ажилтнуудын мэргэшилийн зэргийн болон дипломын хуулбарыг ирүүлнэ.</p> <p>4. Гадны ажилтныг хөлсөөр аөч ажиллуулах тохиолдолд хөлсөөр ажиллуулах гэрээ нь зөвхөн тухайн төсөл, арга хэмжээнд зориулан байгуулсан байх шаардлагатай бөгөөд гэрээний хугацаа, үнийн дүн болон бусад нөхцөлийг тодорхой тусгасан байна</p> <p>Үйлчилгээ үзүүлэхэд ашиглагдах үндсэн тоног төхөөрөмж, техник хэрэгсэл: “Шаардана”</p> <p>Төслийн технологийн иж бүрэн туршилт судалгаа болон технологийн ажлын зураг төслийг боловсруулж гүйцэтгэхэд шаардлагатай тоног төхөөрөмж болон бусад хэрэгслүүдийн жагсаалт, зураг, тэдгээрийн зориулалт, хүчин чадлыг тусгасан мэдээллийг Маягт №11-ийн дагуу тендерт оролцогч бэлтгэн ирүүлнэ.</p> <p>Ижил төстэй үйлчилгээ үзүүлсэн туршлага: “Шаардана”</p> <p>Ижил төстэй ажлын гүйцэтгэгчээр ажилласан байх жилийн тоо: 3 жилээс баагүй</p> <p>Ижил төстэй ажлыг 2021, 2022, 2023 онуудын хугацаанд доод тал нь 1-ээс доошгүй удаа хэрэгжүүлсэн байх</p> <p>Хэрэгжүүлсэн ижил төстэй ажлын гэрээ, гэрээ дүгнэсэн акт болон захиалгачийн тодорхойлолтыг баталгаажуулан ирүүлнэ.</p> <p>Ижил төстэй ажил гэдэгт “уул уурхайн төслийн үйлдвэрлэлийн туршилт, хөгжүүлэлт, тоног төхөөрөмжийн угсралт, үйлчилгээ” гэж ойлгоно.</p> <p>Хэрэгжүүлж байгаа, хэрэгжүүлэх эрх авсан гэрээний талаарх шаардлага: “Шаардана”</p> <p>Техникийн чадавх болон туршлагын шалгуур үзүүлэлт, шаардлагыг хангахыг нотлох бусад шаардлага: “Шаардана”</p> <p>Тухайн төмрийн хүдрийн хорголжлох үйлдвэрлэлийн хагас үйлдвэрлэлийн судалгаа, шинжилгээ хийгдэх тоног төхөөрөмжүүд тухайн туршилт судалгааны ажлыг олон улсын хэмжээнд хүлээн зөвшөөрөгдөх, түүний дүнг заагдсан төслийн технологийн хөгжүүлэлт, ажлын зураг төслийг боловсруулахад ашиглагдах шаардлагыг хангасан байна.</p> <p>Тухайн ажлыг гүйцэтгэгч нь туршилтын ажил болон зураг төслийн ажлыг тухайн төслийг хэрэгжүүлэх эрх бүхий, туршлагатай байна.</p> <p>Тендерийн үнэлгээний заагдсан 2021-2023 оны хугацаанд хийж гүйцэтгэсэн ижил төстэй ажлын туршлагын мэдээлэл, хэрэгжүүлсэн төслийн жагсаалтыг баталгаажуулж ирүүлнэ.</p>
ТШЗ 19.2	Техникийн чадавх болон туршлагын шаардлагыг нотлох баримт бичиг: - Шаардсан хүний нөөцийг мэдээллийг V бүлгийн маягтын дагуу ирүүлэх;

	<ul style="list-style-type: none"> - Оролцогчийн туршлагыг харуулах заасан хугацаанд гүйцэтгэсэн ижил төстэй үйлчилгээ үзүүлсэн гэрээний талаар V бүлгийн Маягт 2,3-ын дагуу бэлтгэсэн мэдээлэл; - Үйлчилгээ үзүүлэхэд ашиглахаар заасан үндсэн тооног төхөөрөмж, техник хэрэгслийн мэдээлэл, (өөрийн өмчлөл, эзэмшилийн, түрээслэх гэх мэт); - техникийн чадавх болон туршлагын талаар заасан шалгуур үзүүлэлт, шаардлагыг хангаж буйг нотлоход шаардлагатай бусад баримт
ТШЗ 19.3	<p>Тусгай зөвшөөрөл/зөвшөөрөл: “Шаардана”</p> <p>Эрх бүхий байгууллагын холбогдох журмын дагуу олгоадсон тусгай зөвшөөрөлтэй байгууллага оролцоно. Үүнд:</p> <ul style="list-style-type: none"> - Тухайн үйлчилгээнд тусгагдсан хагас үйлдвэрлэлийн туршилтын ажлыг гүйцэтгэж технологийн хөгжүүлэлтийн зөвлөмж, тайлан боловсруулах ажлыг эрх бүхий туршлагатай байгууллагын эрхийн сертификат - Тухайн төсөлд заагдсан үйлдвэрлэлийн технологийн болон тооног төхөөрөмжийн зураг төсөл боловсруулах эрх бүхий байгууллага / тусгай зөвшөөрөл-3Т-4.3 “Хөнгөн ба хүнд үйлдвэрийн барилга байгууламжийн технологийн зураг төсөл” түүнтэй дүйцэхүйц/ - Тухайн багц №1-т хамаарах ажлын дүнд боловсруулагдсан төслийн ажлын зураг төсөл нь эрх бүхий байгууллагаар хянагдаж баталгаажуулсан байх <p>Тухайн ажлыг гүйцэтгээгч туршилтын ажил болон зураг төслийн ажлыг тухайн төслийг хэрэгжүүлэх эрх бүхий, туршлагатай аж ахуйн нэгжтэй хамтран/тухайн компаниар туршилт технологийн зураг төсөл/ тендер ирүүлэхийг зөвшөөрнө.</p> <p>Тендерт оролцогч нь хамтран ажиллаач байгууллагын заагдсан ажлыг гүйцэтгэхэд шаардагдах туршилт судалгаа, ажлын зураг төсөл тусгай зөвшөөрлүүдийг холбогдох журмын дагуу ирүүлнэ.</p>
ТШЗ 21.5	Оролцогчийн санал болгосон үнийг гэрээний хэрэгжилтийн явцад: “Тохируулахгүй тогтмол байна”
ТШЗ 24.1	<p>Тендерийн баталгааны дүн:</p> <p>Багц №1: 2,856,450.00 төгрөг</p>
Г. ТЕНДЕР ИЛГЭЭХ, НЭЭХ	
ТШЗ 25.5	<p>Оролцогчдод ил болох баримт бичгийн жагсаалт:</p> <ol style="list-style-type: none"> 1. Улсын бүртгэлийн гэрчилгээний хуулбар /цахим/ 2. Тендерт оролцогчийг төлөөлөх эрх бүхий этгээдийн итгэмжлэл 3. Тусгай зөвшөөрөл: Шаардана./ ТШББ-ийн ΘХ-ийн ТШЗ-19.3-т заасан/ 4. НӨАТ төлөгчийн гэрчилгээ 5. Шүүхийн шийдвэр гүйцэтгэх газрын тодорхойлолт/цахим/ 6. Санхүүгийн тайлангийн мэдээлэл /цахим/

	<p>7. Татвар төлөлтийн тодорхойлолт /цахим/ 8. Нийгмийн даатгалын тодорхойлолт /цахим/ 9. Тендерт заагдсан ажлыг гүйцэтгэх үнийн санал /хийгдэх ажлын үе шатны хуваарь, түүнд хамаарах ажлын хэмжээ, зардлын хамт/ 10. Харилцагч банк, татварын алба, нийгмийн даатгалын байгууллагаас лавлагаа авахад татгалзах зүйлгүй тухай мэдэгдэл</p> <p>Жич: Оролцогч, түншлэгч нь тендер шалгаруулалт зарласнаас хойш хугацаанд цахим системтэй холбогдсон мэдээллийн сангаас “цахим” гэж заагдсан мэдээллүүдийг цахим системээр дамжуулан татан авч, тендер хүлээн авах эцсийн хугацаанаас өмнө уг цахим системийн холбогдох хэсэгт зааварчилгааны дагуу холбон баталгаажуулж илгээнэ. Бүдэг харагдахгүй болон ойлгомжгүй ирүүлсэн тохиолдолд тус тендерийн материалыг хүчингүйд тооцно.</p> <p>Нууцалсан баримт бичиг, мэдээллийн жагсаалтыг Маягт 7-ын дагуу ирүүлнэ. Маягт-7-д ороогүй бусад файл, мэдээллийг цахим системд “Нууцлахгүй” төлөвтэйгээр илгээнэ.</p>
ТШЗ 26.1	<p>Тендер хүлээн авах эцсийн хугацаа нь:</p> <p>Огноо: 2024 оны 11 дүгээр сарын 27</p> <p>Цаг: 09 цаг 00 минут</p>
ТШЗ 26.2	<p>Тендерийн нээлтийг доор дурдсан хугацаанд цахим системээр хийх бөгөөд нээлтийн мэдээллийг оролцогч цахим системээр хүлээн авна.</p> <p>Огноо: 2024 оны 11 дүгээр сарын 27</p> <p>Цаг: 09 цаг 05 минут</p> <p>Тендер нээлтэд оролцох боломжтой газрын хаяг: Улаанбаатар хот, БЗД 22-р хороо, Энхтайваны өргөн чөлөө – 98, “Монголросцветмет” ТӨҮГ</p>
Д. ТЕНДЕРИЙГ ХЯНАН ҮЗЭХ, ҮНЭЛЭХ	
ТШЗ 31.1	Тендер үнэлэх үндсэн шалгуурыг харьцуулах үнээс өөрөөр тогтоох эсэх: [“Үгүй”]
Е. МЭДЭГДЭЛ ХҮРГҮҮЛЭХ, ГЭРЭЭ БАЙГУУЛАХ	
ТШЗ 36.1	Шалгарсан оролцогч гүйцэтгэлийн баталгаа ирүүлэх эсэх: “Тийм”

III БҮЛЭГ. ТЕХНИКИЙН ТОДОРХОЙЛОЛТ, ТАВИГДАХ ШААРДЛАГА

ТЕНДЕРИЙН НЭР: “ХОРГОЛЖИНГИЙН ҮЙЛДВЭР БАРИХ БАГЦ-1

Төмрийн хүдрийн баяжмалыг хорголжлох үйлдвэрийн хагас үйлдвэрлэлийн туршилт, үйлдвэрлэлийн технологийн зураг төсөл боловсруулах

ТЕНДЕРИЙН ДУГААР: МРЦМ/20240101299

№	Үзүүлэлт	Тавигдах шаардлага								
1	Техникийн тодорхойлолт боловсруулах үндэслэл	УУХҮ-ийн Яам, АМХЭГ, Эрдэс Баялгийн Мэргэжлийн Зөвлөлийн 2023 оны 5 дугаар сарын 18-ны өдрийн БҮ- 2023 01-02 тоот дүгнэлтээр батлагдсан “Хэнтий аймгийн Бор-Өндөр сумын нутагт байрлах төмрийн хүдрийн баяжмалыг хорголжлох үйлдвэрийн техник-эдийн засгийн үндэслэл”								
2	Зориулалт, хүчин чадал	<p>Зориулалт: “Монголросцветмет” ТӨҮГ-ын “Бор-Өндөр” УБҮ-ийн төмрийн хүдрийн баяжмалыг бөөнцөглөж төмрийн хүдрийн хорголжин үйлдвэрлэх.</p> <p>Жилийн хүчин чадал: 200 мян.тн төмрийн хүдрийн хорголжин үйлдвэрлэх</p>								
3	Техникийн тодорхойлолт боловсруулахад ашиглах материал	<ol style="list-style-type: none"> “Хэнтий аймгийн Бор-Өндөр сумын нутагт байрлах төмрийн хүдрийн баяжмалыг хорголжлох үйлдвэрийн техник-эдийн засгийн үндэслэл” Үйлдвэрлэлийн дэвсгэр зураг Технологийн үндсэн тоног төхөөрөмжүүдийн судалгаа 								
4	Байршил эдэлбэр газрын хэмжээ	<p>Хэнтий аймаг, Бор-Өндөр сум, “Бор-Өндөр” УБҮ-ийн үйлдвэрлэлийн талбай:</p> <ul style="list-style-type: none"> - Ажлын талбай нь: 267 608 м2 - Бор-Өндөр сумын ЗД-ын 2021 оны 12 дугаар сарын 08-ны А/273 тоот захирамж - Газар эзэмших эрхийн гэрчилгээ _0000031621 - Эзэмшил газрын зураг /Хавсралт №1/ 								
5	Технологи, туршилтын ажил	<ol style="list-style-type: none"> Төмрийн хүдрийг хорголжлох хагас үйлдвэрлэлийн туршилтыг “Бор-Өндөр” УБҮ-ээс гарч байгаа Fe-65% агуулгатай төмрийн хүдрийн нойтон баяжмалыг ашиглан явуулна. Тухайн туршилтад орон нутгийн нүүрс болон холбогч материал ашиглах боломжийг судална. Тухайн туршилтын дүнгээр төмрийн хүдрийг хорголжлох технологийн сонголт хийж захиалагчид танилцуулна. Технологийн туршилтын дүнг үндэслэн технологийн ажлын зураг хийж эрх бүхий байгууллагаар баталгаажуулна. Үйлдвэрлэгдэх төмрийн хүдрийн хорголж нь металлургийн үйлдвэрлэлийн шаардлагыг бүрэн хангах нөхцлийг бүрдүүлнэ. 								
6	Хорголжингийн чанарын стандарт үзүүлэлт	<p>Хүчин чадал жилд: 200 мян.тн төмрийн хүдрийн хорголжлох үйлдвэр. Түүхий эд:</p> <ul style="list-style-type: none"> ➢ Төмрийн хүдрийн нойтон баяжмал <ul style="list-style-type: none"> • Төмрийн агуулга 65%-аас дээш • Баяжмалын үндсэн эрдэс: Магнетит • Чийглэг 8-10 % Ширхэглэл <table border="1" style="margin-left: 20px;"> <tr> <td>• 0.71- 1 мм</td> <td>0.06%</td> </tr> <tr> <td>• 0.5-0.71 мм</td> <td>0.22%</td> </tr> <tr> <td>• 0.355-0.5 мм</td> <td>0.55%</td> </tr> <tr> <td>• 0.25-0.355 мм</td> <td>1.5%</td> </tr> </table> 	• 0.71- 1 мм	0.06%	• 0.5-0.71 мм	0.22%	• 0.355-0.5 мм	0.55%	• 0.25-0.355 мм	1.5%
• 0.71- 1 мм	0.06%									
• 0.5-0.71 мм	0.22%									
• 0.355-0.5 мм	0.55%									
• 0.25-0.355 мм	1.5%									

		<ul style="list-style-type: none"> • 0.18-0.25 мм 6.45% • 0.125-0.18 мм 13.43% • 0.09 -0.125 мм 12.89% • 0.063-0.09 мм 13.43% • 0.045-0.063 мм 11.05% • 0.045 мм хүртэл 40.42% <p>➤ Холбогч (бентонит, шохойн чулуу) /төслөөр тодорхойлно.</p> <p>➤ Нүүрс /орон нутгийн нүүрсний сонголтыг төслөөр тодорхойлно./ Илчлэг 5000 Ккал/кг min</p> <p>Тэмрийн хүдрийн хорголжинд тавигдах өрөнхий шаардлага</p> <p>Физик шинж чанар</p> <ul style="list-style-type: none"> • Фракцийн хэмжээ 8 - 20мм 9 - 16 мм 93% min <5 мм 5% max >18 мм 5% max • Нягт 2.1 +/- 0.2% • Thumble index >6,35мм 94% min <0.5 мм 5% max • Cold compression strength Φ10-12 мм 250 кг/pellet min • Porosity 23.0 +/-2% • Reducibility at 900 degree 0.6%/min (minimum) • Free swelling index 18% max • Softening temperature 1125°C minimum • Tumbler index +6.2 mm >92%, -0.5 mm 5 %max <p>Химийн найрлага</p> <ul style="list-style-type: none"> • Fe total 63% min • SiO₂+AL₂O₃ 5% max • CaO+MgO 3% max • P 0.05% max • S 0.015% max • Суурилаг чанар 0.3 min <p>Үйлдвэрлэгдэх хорголжийн чанарын үзүүлэлтэд тавигдах шаардлага зөвхөн дээр заагдсан үзүүлэлтээр хязгаарлагдахгүй. Үндсэн шаардлага нь энэхүү техникийн тодорхойлолтын “Технологи, туршилтын ажил” хэсэгт “Үйлдвэрлэгдэх тэмрийн хүдрийн хорголж нь металлургийн үйлдвэрлэлд ашиглагдах технологийн шаардлагыг бүрэн хангасан байх нөхцлийг бүрдүүлнэ” заалтыг хангасан байна.</p>
7	Хорголжлох үйлдвэрлэх технологи, тоног төхөөрөмжүүд	<p>Хорголжлох үйлдвэрлэх технологийн схем</p> <p>Захиалгачийн төлөвлөж байгаа хорголжлох үйлдвэрийн технологийн схемийн санал:</p> <p>Тэмрийн хүдрийн баяжмал - Бентонит - Шохойн чулууг холих - Чийглэх холих - Хорголжлох - Шигших - Хаягдал хорголжинг дахин чийглэн холих- Хатаах 150°C - Хатаах 700-900°C - Шатаах 1100-1250°C - Хөргөх – Хорголж хадгалах</p> <p>Мөн түүнчлэн технологийн зориулалттай ашиглагдах холбогч, нэмэлт материал болон нүүрс бэлтгэх, шатаах болон үйлдвэрлэл явуулахад шаардлагатай дэд бүтэц, үйлдвэрлэлийн явцад ялгарах хий, шингэн болон тоос, хатуу хаягдлыг шүүх боловсруулах хэсгүүд зэрэг шат дамжлагууд төсөлд тусгагдсан байна.</p> <p>Хорголжлох үйлдвэрлэлийн технологийн тоног төхөөрөмж</p> <ul style="list-style-type: none"> • Түүхий эд хадгалах, бэлтгэх /тэмрийн хүдрийн баяжмал, нэмэлт материал, холбогч, нүүрс/

		<ul style="list-style-type: none"> Хорголжийн хольц бэлтгэх тоног төхөөрөмж Хорголжлох тоног төхөөрөмж Ф6000 мм Түүхий хорголжийн хяналтын шигшүүр Гинжит тэжээгч (2.4x28м) бүхий эргэгч шатаах барабан зуух Ф3.0x22.5м Хөргөлтийн циркуляр эргэлттэй зуух 30м2 Шатаасан хорголжийн хяналтын шигшүүр Бүтээгдэхүүнийг тээвэрлэх систем, агуулах Технологийн дамжлагын конвойерийн иж бүрэн систем Тоос зайлцуулах, буцаах систем Үйлдвэрийн доторх дэд бүтэц, шугам хоолой г.м. <p>Нөхцөл: Үйлдвэрлэлийн технологи, ашиглагдах тоног төхөөрөмж нь орчин үеийн, цахилгаан эрчим хүчний хэмнэлттэй, байгаль орчинд ээлтэй шийдэл бүхий байна.</p>
8	Ажил гүйцэтгэх хугацаа	Захиалагч шалгарсан гүйцэтгэгч талуудын хооронд байгуулсан гэрээний дагуу 8 сар.
9	Тендерт оролцох ААН-д шаардагдах нөхцөлүүд	<p>Тоног төхөөрөмж үйлдвэрлэгч байгууллагатай байгуулсан хамтын ажиллагааны гэрээ болон технологийн зураг боловсруулах эрх бүхий байгууллагатай хийсэн гэрээ, тухайн компанийн тусгай зөвшөөрөл,</p> <p>Тендерт заагдсан хагас үйлдвэрлэлийн туршилт судалгаа, шинжилгээний ажлыг гүйцэтгэх, дүгнэлт тайлан, зөвлөмж боловсруулах чадвартай боловсон хүчинтэй байх, Төслийн судалгаа, туршилт шинжилгээний ажлын дүнгээр технологийн ажлын иж бүрэн зураг төсөл, баримт бичиг боловсруулах багийн боловсон хүчний мэргэшил, туршлагын шаардлага нь ТШББ-ийн ӨХ-ийн ТШЗ 19.1-т заасан шаардлагыг хангасан байна.</p>
10	Төсөл хэрэгжүүлэхэд тавигдах онцгой нөхцөл, шаардлага	<p>Үйлдвэрлэлийн технологи, ашиглагдах тоног төхөөрөмж нь орчин үеийн, цахилгаан эрчим хүчний хэмнэлттэй, байгаль орчинд ээлтэй шийдэл бүхий байна.</p> <p>Хорголжлох үйлдвэрийг Монгол улсын газар хөдлөлтийн нөхцөл, цаг урын бүс, ялангуяа хүйтний улиралд үйл ажиллагаа явуулахтай холбогдуулан төмрийн хүдрийн баяжмал болон холбогчийг халаах, хатаах зэрэг шаардлагатай нөхцөлийг төсөлд тусгана.</p> <p>Монгол улсын байгаль орчныг хамгаалах стандарт нормын шаардлагыг хангасан байх</p> <p>Төслийн хүрээнд ашиглахаар төлөвлөсөн механик, цахилгаан зэрэг тоног төхөөрөмжүүд, тоноглол, эд аngiud олон улсын холбогдох стандартуудын шаардлагыг хангасан байна.</p>
11	Төслийн боловсруулах баримт бичгийн иж бүрдэл	<p><u>Баримт бичгийн иж бүрдэл:</u></p> <ul style="list-style-type: none"> - Хагас үйлдвэрлэлийн туршилтад төмрийн хүдрийн Fe-65% агуулгатай нойтон баяжмалаар хорголжлох үйлдвэрлэлийн технологийн туршилт, тайлан (эрх бүхий байгууллагаар баталгаажсан) - Технологийн схем зураг (эрх бүхий байгууллагаар баталгаажсан) - Төмрийн хүдрийн хорголжлох үйлдвэрлэлийн технологийн арга зүйн заавар, технологийн иж бүрэн ажлын зураг төсөл <p>Төслийн баримт бичгийг Microsoft office программын (Word, Excel, Power point, MS-project , Autocad г.м.) ашиглан цахим болон цаасан хэлбэрээр хүлээлгэн өгөх</p>

IV БҮЛЭГ. ТЕНДЕРИЙН ҮНЭЛГЭЭНД ХАРГАЛЗАХ НЭМЭЛТ ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТҮҮД

Өгөгдлийн хүснэгтийн ТШЗ 32.1-д үнэлгээнд харгалзах шалгуур үзүүлэлт ашиглахаар заасан бол захиалагч тендерийн үнэлгээнд харгалзах шалгуур үзүүлэлтийг үлдээж бусад шалгуур үзүүлэлтийг хасна.

Энэ бүлэг нь ТШЗ-ны зүйл бөгөөд захиалагч өгөгдлийн хүснэгтэд тусгайлан зөвшөөрсөн бол тендерийн үнэлгээ хийхэд тендерийн маягтад тусгасан үнийн саналаас гадна энэ хэсэгт заасан нэг буюу хэд хэдэн шалгуур үзүүлэлтийг мөнгөөр илэрхийлэн, тендерийн үнийг хийсвэрээр нэмэгдүүлэх замаар тендерийн харьцуулах үнийг тодорхойлон үнэлгээ хийх зорилгоор ашиглана.

Захиалагч энэ хэсэгт зааснаас өөр шалгуур үзүүлэлтийг үнэлгээнд харгалзахгүй.

1. Үйлчилгээ дуусгах хугацаа: “Ашиглахгүй”

Хэрэв “ашиглах” бол: Тухайн тендер шалгаруулалтад холбогдох гэрээний дагуу гүйцэтгэх хуваарьт заасан зөвшөөрөгдөх хугацааны хооронд (гэрээний үүргийн гүйцэтгэлийг эхлэх эхний өдрөөс хойш үүрэг гүйцэтгэвэл зохих сүүлчийн өдрийг оролцуулан) гэрээний үүргийг хэрэгжүүлсэн байх шаардлагатай. Захиалагчийн заасан гэрээний үүрэг гүйцэтгэх хугацаанаас өмнө гүйцэтгэх санал ирүүлсэн тендерт урамшуулал, эсхүл үнэлгээнд бусад тендерээс давуу нөхцөл олгохгүй.

Захиалагч уг шалгуур үзүүлэлтийг үнэлгээнд ашиглахаар тусгайлан зөвшөөрсөн тохиолдолд захиалагчаас заасан гэрээний гүйцэтгэлийн хуваарьт зааснаас хоцорч гүйцэтгэхээр санал болгосон тендерээс татгалзахгүй ба үнэлгээнд харгалзах зорилгоор хоцорсон хоног тутамд [хувь бичих]-аар тооцож тендерийн харьцуулах үнэ дээр нэмнэ.

Захиалагчаас заасан гэрээний гүйцэтгэлийн хуваарьт зааснаас [тоо бичих]-аас илүү [“cap”, “өдөр” гэдэг үгнээс сонгож бичих] хоцроож гүйцэтгэх санал болгосон тендерээс татгалзана. Харин өгөгдлийн хүснэгтэд тусгайлан зөвшөөрөөгүй тохиолдолд захиалагчийн тоогоосон гүйцэтгэлийн хуваариас хойш гүйцэтгэх санал ирүүлсэн тендерийг шаардлагад нийцээгүй гэж үзнэ.

2. Үйлчилгээний гэрээний гүйцэтгэлийн дараах үйлчилгээг захиалагчийн заасан газар үзүүлэх боломж: “Ашиглахгүй”

Хэрэв “ашиглах” бол урсгал засвар үйлчилгээний цэг бий болгох болон үндсэн/шаардлагатай сэлбэг хэрэгслээр хангахын тулд захиалагчид шаардагдах зардлыг тусад нь үнэлж ирүүлсэн бол түүнийг үнэлгээний зорилгоор тендерийн харьцуулах үнэ дээр нэмж үнэлнэ.

3. Байгаль орчинд нөлөөлөх байдал: “Ашиглахгүй”

Гэрээний гүйцэтгэлийн явцад байгаль орчинд нөлөөлөх байдалтай холбоотой дараах үзүүлэлтийг үнэлгээнд харгалзан үзэж, тендерийн харьцуулах үнэ дээр хийсвэрээр нэмж үнэлнэ. [Захиалагч харгалзан үзэх шалгуур үзүүлэлт, түүнд хамаарах утгыг доор жагсааж бичих.]

4. Хуульд нийцсэн бусад шалгуур үзүүлэлт “Ашиглахгүй”

V БҮЛЭГ.ТЕНДЕРИЙН ЖИШИГ МАЯГТ Маягт 1.Тендер илгээх маягт

[огноо]

[Захиалагч байгууллагын нэр]-д

Манай [оролцогчийн нэр] нь танай байгууллагаас зарласан [тендер шалгаруулалтын нэр, дугаар] тендер шалгаруулалтад [үнийн хөнгөлөлт тооцоогүй тендерийн үнийг тоогоор болон үсгээр] төгрөгөөр тендерийн баримт бичигт заасан хуваарийн дагуу үйлчилгээ үзүүлэхээр, дор дурдсан нөхцөлийг баталж энэхүү тендер (цаашид “тендер” гэх)-ийг хүргүүлж байна. Үүнд:

1. Тендерийн баримт бичиг, түүнд заасан гэрээний нөхцөл (гэрээний ерөнхий нөхцөл, тусгай нөхцөл, гэрээ баталгаажуулах маягт)-тэй танилцаж, бүрэн хүлээн зөвшөөрч тендер шалгаруулалтад оролцсон.
2. Оролцогч, түүний түншлэлийн гишүүн худалдан авах ажиллагаанд оролцох холбоотой хуулиар хориглосон нөхцөлд хамаarahгүй бөгөөд үүний дотор дараах нөхцөлийг гэрчилж байна:
 - 2.1. Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.1-д заасан нөхцөл үүсээгүй;
 - 2.2. Нөлөө бүхий хувьцаа эзэмшигч, түүний эцсийн өмчлөгч, хөрөнгө эзэмшигч, хамтрагч, эсхүл эдгээрийг гүйцэтгэж байгаа хувиараа аж ахуй эрхлэгч нь Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2 дахь хэсэгт заасан албан тушаал эрхэлж байсан болон эрхэлж байгаа хүн, эсхүл түүнтэй хамаарал бүхий этгээд биш;
 - 2.3. Захиалагчийн удирдлага, хяналт, захиргаанд ажилладаг албан тушаалтанд ашиг олгодоггүй.
